



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын И байр, Утас/Факс: 7058-4203

2023.04.14 № 534

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН НӨХӨН СОНГУУЛЬД  
ОРОЛЦОХ НАМ, ЭВСЛИЙН  
УДИРДЛАГАД

Мөрийн хөтөлбөр, хандивын  
тайлан ирүүлэх тухай

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9-т заасны дагуу сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн сонгуулийг 2023 оны 06 дугаар сарын 18-ны өдөр нэгдсэн журмаар зохион байгуулах тухай Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр гарсан ба манай аймгийн Баянтүмэн, Халхгол, Чойбалсан суманд нөхөн сонгууль зохион байгуулагдахаар байна.

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.8 дахь хэсэгт “Орон нутгийн Хурлын ээлжит бус, нөхөн, дахин сонгуулиар нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь төрийн аудитын дээд байгууллагаас тогтоосон хугацаанд сонгуулийн мөрийн хөтөлбөр болон энэ хуулийн 25.3.6, 25.4.6-д заасан хандивын тайландаа дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын байгууллагын орон нутаг дахь салбар байгууллагад хүргүүлнэ”, 37.10 дэх хэсэгт “Төрийн аудитын байгууллага нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөр энэ хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэх талаарх дүгнэлтийг санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө гаргаж, тухайн шатны сонгуулийн хороонд хүргүүлнэ” гэж тус тус хуульчилсан байдаг. Гэтэл 2023 оны 04 дүгээр сарын 14-ний байдлаар нам, эвсэл нь мөрийн хөтөлбөр, хандивын тайлангаа ирүүлээгүй байна.

Иймд сонгуулийн мөрийн хөтөлбөр, хандивын тайлангаа 2023 оны 04 дүгээр сарын 17-ны дотор ирүүлнэ үү.

Сонгуулийн ерөнхий хорооноос Үндэсний аудитын газарт ирүүлсэн албан бичгийг хавсаргав.

Хавсралт: 1. хуудастай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

011020570